



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

KFW



2023

Биологийн олон янз байдлыг
хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд
дасан зохицох төсөл II, III шат

2023 оны төслийн
үнэлгээний тайлан

Төсөл
хэрэгжүүлэх
нэгж



2024 оны 02 дугаар сар

ГАРЧИГ

1. ХУРААНГҮЙ	1
2. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТҮҮХ, ТӨСЛИЙН ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНИЙ ҮНДЭСЛЭЛ, ТААМАГЛАЛ БА ЭРСДЭЛ ҮҮСЭХ МАГАДЛАЛ, ТЭДГЭЭРИЙН ТӨСӨЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	1
2.1. Төслийн үйл ажиллагааны товч түүх	1
2.2. Төслийн орчны өөрчлөлт, түүний үндэслэл, таамаглал ба эрсдэл үүсэх магадлал, тэдгээрийн төсөлд үзүүлэх нөлөө.....	2
2.3. Эрсдэл үүсэх магадлал, тэдгээрийн төсөлд үзүүлэх нөлөө	6
3. ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ХЭРЭГЛЭСЭН АРГА ЗҮЙ, СУЛ ТАЛ	17
4. ҮНЭЛГЭЭ	19
4.1. Өнөөгийн хэрэгцээтэй тохирч буй байдал буюу хамааралтай байдал	21
4.2. Төслийн хүлээгдэж буй үр нөлөө	21
4.3. Хэрэгжилтийн үр ашгийн үнэлгээ.....	22
5. НИЙЦТЭЙ БАЙДАЛ БА ТОГТВОРТОЙ БАЙДАЛ.....	24
5.1. Стратегийн зорилготой нийцтэй байдал.....	24
5.2. Бодлогын орчин	26
5.3. Эдийн засаг, санхүүгийн үндэслэл.....	27
5.4. Институтийн хүчин чадал	28
5.5. Нийгэм-соёлын асуудал	28
5.6. Оролцоо ба өмчлөл	29
5.7. Жендер	29
5.8. Байгаль орчин.....	29
5.9. Тохиромжит технологи	29
6. ХЭРЭГЖИЛТИЙН ҮР АШГИЙН ҮНЭЛГЭЭ.....	29
7. ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ: ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ САНАЛУУД, СУРГАМЖ.....	30

Товчилсон үгсийн жагсаалт

Товчилсон үг	Тайлбар
БОАЖЯ	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
БОНХАЖЯ	Байгаль Орчин, Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын Яам
БОНХЯ	Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яам
БОЯБ	Биологийн олон янз байдал
БОЯБХУАӨДЗ	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох
БЦГ	Байгалийн цогцолборт газар
ГСБЗБ/ KfW	Германы Сэргээн босголт Зээлийн банк
ГХА	Гэрээ хариуцсан ажилтан
ДЦГ	Дархан цаазат газар
ЗБ	Зөвлөх баг
ЗГ	Засгийн Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
МУ	Монгол Улс
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МТ	Менежментийн төлөвлөгөө
МУАБҮ	Менежментийн үр ашигт байдлын үнэлгээ
НД	Нийгмийн даатгал
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОБ	Орчны бүс
УХ	Удирдах хороо
ТББ	Тендерийн бичиг баримт
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах
ТХБНУГ	Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газар
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
ТХГНУГ	Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газар
ТХН	Төсөл Хэрэгжүүлэх Нэгж
УТХГ	Улсын тусгай хамгаалалттай газар
УХ	Удирдах Хороо
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗ	Хамгаалалтын захиргаа
СЯ	Сангийн яам
СХОХ	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Төслийн санхүүжилтийн хуваарь, 2023 оны санхүүгийн гүйцэтгэл 18

Хүснэгт 2 Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөхөд анхаарах асуудал, санал зөвлөмж

Хүснэгт 3 Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад анхаарах асуудал, санал зөвлөмж

Хүснэгт 4 Хугацаа сунгасан гэрээний мэдээлэл, анхаарах асуудал, зөвлөмж 20

Хүснэгт 5 Төслийн ХШҮ, ил тод байдал

Хүснэгт 6 Үнэлгээний аргачлал, үнэлгээний хүснэгт Хүснэгт 7 ХАА-г зохион байгуулахад анхаарах асуудал, санал зөвлөмж

Хүснэгт 8

Хүснэгт 12. Төсөл уялдан хэрэгжих бодлогын бичиг баримтууд

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1. Төслийн I шатны Засгийн газар хоорондын хэлэлцээр, санхүүжилтийн гэрээ болон Тусгай гэрээ

Хавсралт 2. Төслийн II, III шатны Засгийн газар хоорондын хэлэлцээр, санхүүжилтийн гэрээ болон Тусгай гэрээ

Хавсралт 3 Төслийн II, III үе шатанд хамрагдаж буй газар нутаг

Хавсралт 4 Мониторингийн логик хүрээ, Logframe буюу мониторингийн тогтолцоо

Хавсралт 5 Хуулийн ажилтны зайлиггүй хэрэгцээ шаардлага

Хавсралт 6 Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд ХШҮ хийх үнэлгээний хүснэгт

Хавсралт 7 Германы сэргээн босголт зээлийн (KfW) банкны 2023 оны явцын үнэлгээний мөрөөр гарсан хурлын тэмдэглэлийн биелэлт, авах арга хэмжээ, анхаарах асуудал

Эх сурвалжууд:

<https://www.parliament.mn/nn/18989/>

<https://met.gov.mn/>

<https://www.zogii.mn/post/7585747>

<https://shilendans.gov.mn/organization/20946?ry=2023>

1. ХУРААНГҮЙ

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журмыг батлах тухай” 176 дугаар тогтоолтой холбогдуулан Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11ний өдрийн 04 дүгээр тушаалын хавсралт маягтын дагуу БОАЖЯ-ны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III” төслийн үнэлгээний тайланг 2023 оны жилийн эцсийн байдлаар гаргалаа.

Энэхүү тайланд төсөл хэрэгжиж эхэлсэн товч түүх, төсөв санхүүжилт, институтийн бүтэц, хүчин чадал, үндсэн зорилго, зорилтууд тэдгээрийн хэрэгжилт, төрөөс баримталж буй стратеги, тогтвортой хөгжил, байгаль орчны бодлоготой хэрхэн нийцэж байгаа талаар товч танилцуулж, төслийн үйл ажиллагааны үнэлгээний зорилго, хэрэглэсэн арга зүй, үр дүнтэй байдал, хүлээгдэж буй үр нөлөө, төсөлд оруулах шаардлагатай өөрчлөлт, түүний үндэслэл, тэдгээрийн төсөлд үзүүлэх нөлөө зэрэг журамд тусгагдсан бусад асуудлыг тусгасан болно.

2. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТҮҮХ, ТӨСЛИЙН ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНИЙ ҮНДЭСЛЭЛ, ТААМАГЛАЛ БА ЭРСДЭЛ ҮҮСЭХ МАГАДЛАЛ, ТЭДГЭЭРИЙН ТӨСӨЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

2.1. Төслийн үйл ажиллагааны товч түүх

2012 оны 03 дугаар сард Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газрын хооронд байгуулсан Хөгжлийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн үеэр Монгол орны уур амьсгалын өөрчлөлтөд голлон анхаарч, биологийн олон янз байдлын хамгаалал, нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх чиглэлд хамтран ажиллах асуудлыг тусгасан.

Тус хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор 2013 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Монгол Улсын Сангийн Яам Германы Сэргээн босголт Зээлийн банк (ГСБЗБ)-тай “Санхүүжилтийн гэрээ”, БОНХЯ, ГСБЗБ-тай “Тусгай гэрээ”-г тус тус байгуулснаар “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” (БОЯБХУАӨДЗ) төслийг санхүүгийн хамтын ажиллагааны буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

(Хавсралт 1. Төслийн I шатны Засгийн газар хоорондын хэлэлцээр, санхүүжилтийн гэрээ болон Тусгай гэрээ)

“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн I шатны зорилго нь Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг (орчны бүс болон экологийн коридор) бэхжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүс дэх орон нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд оршсон.

Монгол орны Тусгай хамгаалалттай газар нутаг нь Баруун, Зүүн, Төв, Хангай, Говь гэсэн газар зүйн 5 бүсэд хуваагддаг ба төслийн I шат нь ХБНГУ-ын Засгийн газраас 11.5 сая евро, Монгол Улсын Засгийн Газар 3.5 сая евро буюу 6.65 тэрбум төгрөг буюу нийт 15.3 сая еврогийн санхүүжилттэйгээр УТХГ-ын Төв, Хангай, Зүүн бүсүүдэд 2015-2022 онуудад хэрэгжиж дууссан.

Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газрын хоорондын Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны 2016 оны хэлэлцээрээр төслийн II шатыг ТХГН-ийн Баруун бүсэд 19.5 сая еврогийн, 2017 оны хэлэлцээрээр III үе шатыг Говийн бүсэд 8 сая еврогийн санхүүжилттэйгээр хэрэгжүүлэхээр тус тус шийдвэрлэсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газар (түүнийг төлөөлөн Байгаль орчин, аялал жуулчлалын яам), Германы Засгийн газар (түүнийг төлөөлсөн ГСБЗ/ KfW банкны) хооронд 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдөр болон 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдөр Тусгай гэрээг тус тус байгуулсан. *(Хавсралт 2. Төслийн II, III шатны Засгийн газар хоорондын хэлэлцээр, санхүүжилтийн гэрээ болон Тусгай гэрээ)*

Төслийн II, III шатны хэрэгжих хугацаа: 2020- 2027 /7 жил/

Үе шатууд:

1. **Эхлэл үе (6 сар):** Төсөл хэрэгжүүлэх бодлого, журмуудыг боловсруулах, дэд төслийн саналуудыг хүлээж авах, сургалтын хөтөлбөр гаргах, ТХГН-уудын МТ-г сайжруулах;
2. **Хэрэгжилтийн үе (72 сар).** Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
3. **Дүгнэх үе (6 сар):** Үйл ажиллагааг дүгнэх, үнэлгээ хийх;

Төслийн II, III шат эхлэхтэй холбогдуулан ХБНГУ-ын KfW банкнаас Зөвлөх багийг сонгон шалгаруулж, 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдөр БОАЖЯ-ны ТНБД болон “Эко консалтинг” ХХК хоорондын хамтын ажиллагааны гэрээг байгуулснаар төслийн II, III шат ХБНГУ-ын Засгийн газраас 27.5 сая евро, Монгол Улсын Засгийн Газраас 5.27 сая евро буюу 14.8 тэрбум төгрөг буюу нийт 32.77 сая еврогийн санхүүжилттэйгээр УТХГ-ын Баруун болон Говийн бүсүүдэд албан ёсоор эхэлсэн.

(Хавсралт 3 Төслийн II, III үе шатанд хамрагдаж буй газар нутаг)


2.2. Төслийн орчны өөрчлөлт, түүний үндэслэл, таамаглал ба эрсдэл үүсэх магадлал, тэдгээрийн төсөлд үзүүлэх нөлөө

Төслийн үндсэн баримт бичиг нь Монгол Улсын Засгийн газар болон ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, ГСБЗБ болон МУ-ын Сангийн яам хоорондын Санхүүжилтийн гэрээ болон ГСБЗБ, БОАЖЯ-тай байгуулсан “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төсөл хэрэгжүүлэх Тусгай гэрээ бөгөөд дээрх баримт бичгийг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын дагуу батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэл, тайлагнах” журамтай давхар мөрдөж ажилладгаараа Монгол улсад хэрэгжиж буй олон улсын бусад төсөл хөтөлбөрөөс онцлог болно.

- Санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж байгаа төслийн хувьд худалдан авах ажиллагаа, түүний бэлтгэл ажил болох хэрэгцээ шаардлагын судалгаа хийх, техникийн тодорхойлолт, тендерийн бичиг баримт, ажлын даалгаврыг боловсруулах болон ХАА-ны үр дүнд байгуулагдах ажил, бараа, зөвлөх үйлчилгээ нийлүүлэх ажлын гэрээ, тэдгээрийн хэрэгжилт зэрэг нь төслийн үйл ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэнэ.

- Төслийн II, III шат 2020-2027 онуудад нийт 27,5 сая еврогийн санхүүжилттэйгээр хэрэгжих нь нэг жилд 4 сая орчим буюу 12 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөгдөнө.

Хүснэгт 1 Төслийн санхүүжилтийн хуваарь, 2023 оны санхүүгийн гүйцэтгэл



- Монгол Улс, ХБНГУ хоорондын Засгийн Газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд МУ-ын ЗГ-аас төслийн II, III шатны үйл ажиллагаанд нийт 14.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор тохирсны дагуу төслийн удирдлага, санхүүгийн ажилтан нар 2023 оны III-IV улиралд Сангийн яам, холбогдох удирдлагуудад тус тус танилцуулсан. Үүнд: ТХН-ийн урсгал зардалд-0,8 тэрбум төгрөг бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн

хөтөлбөр 2020-2024, Алсын Хараа 2050, Засгийн газрын үндсэн чиглэлийн бодлого 2021-2025, яамны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг уялдуулж ТХГН-ийн хөрөнгө оруулалтад 1,5 тэрбум төгрөг нийтдээ 2023 оны жилийн эцсийн байдлаар 2,3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Цаашид гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт нь төслийн дараагийн үе шатны хэрэгжилт, донор байгууллагын санхүүжилтэд нөлөөлөх тул хоёр талын гэрээнд Монголын талын хөрөнгө оруулалтын биелэлтийг хангах зорилгоор төслийн 2024 оны төсвийн саналд 5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг тусгаж, батлуулахаар ажиллаж байна.

- Төслийн нөлөөллийн мониторингийн үнэлгээг хийхтэй холбогдуулан тайлангийн хугацаанд төслийн зөвлөх баг мониторингийн логик хүрээ, тогтолцоог боловсруулж, 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр тус ажлын тайланг хэлэлцэн эцэслэж, санхүүжүүлэгч байгууллагад зөвшөөрөл авахаар илгээсэн. Нөлөөллийн мониторингийн гарын авлага, мониторингийн логик хүрээ, матриц, дижитал мониторинг систем зэрэг тогтолцооны дагуу 2024 онд ТХН-ийн ХШҮ-ний ажилтан, ТХГН-ийн хамгаалалтын захиргаа, холбогдох байгаль орчны байгууллагуудын хяналт, хуулийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн, сургалт, судалгаа хариуцсан мэргэжилтэн нарыг хамруулсан сургалтыг 2024 онд хийхээр төлөвлөсөн.

(Хавсралт 4 Мониторингийн логик хүрээ, Logframe буюу мониторингийн тогтолцоо)

- БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний А/19 дугаартай “Яамны албан хаагчдыг албан тушаал, ажлын байрны нэр /чиг үүрэг/, ангилал, зэрэглэл батлах тухай” тушаалаар яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн орон тоо болон албан тушаалын жагсаалтыг нийт 9 газар, 4 хэлтэстэйгээр тус тус шинэчлэн баталсан. БОАЖЯ-ны ТХБНУГ-ын бүтэц өөрчлөгдөж, Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газар (ТХГНБЗГ) болж солигдон, 10 хүний орон тоотойгоор баталсан. БОАЖЯ-ны бүтцийн өөрчлөлттэй холбогдуулан төслийн хүрээнд 2023 онд нийт 47 тушаалыг албажуулснаас 17 нь буюу 37% нь Үнэлгээний хорооны гишүүдийг солих “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” тушаал байна.

- Тайлангийн хугацаанд хүний нөөцийн өөрчлөлтийн хувьд:
 - о ГСБЗ (KfW) банкны Монгол дахь төлөөлөгч /2023.05 сард/,
 - о төслийн удирдах хорооны дарга /2023.01 сард/,
 - о төслийн захирал 2 удаа /2023.04 болон 05 сард/,
 - о ТХГНБЗГ-ын төсөл хариуцсан мэргэжилтэн /2023.03 болон 05/,
 - о төслийн зөвлөх багийн техникийн ахлах зөвлөх /2023 оны 02 сард/,
 - о төслийн зохицуулагч /2023.05 сард/
 - о захиргаа, удирдлагын ажилтан 2 удаа /2023.04 болон 11 сард/
 - о төслийн жолооч /2023.10 сард/солигдсон
 - о хуулийн ажилтны гэрээ 2022 оны 12 сараар дуусгавар болж, сонгон шалгаруулалтыг зарласан ч ажил горилогч ирээгүй, тайлангийн хугацаанд хуулийн ажилтангүй ажилласан.

(Хавсралт 5 Төслийн үйл ажиллагаанд гарч буй хуулийн асуудлууд, хуулийн ажилтны хэрэгцээ шаардлага)

- Төслийн I шат 2022 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсноор төслийн I болон II, III шатыг 3 жил зэрэгцүүлэн хэрэгжүүлж байсан ТХН-ийн ажлын ачаалал багассан.

- БОАЖЯ-ны ТХГНБЗГ-аас ТХН-ийн ажилтан нарын 2022 оны хөлсөөр ажиллах гэрээг үнэлэх үеэр АБТ-ийг шинэчлэх чиглэл өгсөн. Тайлангийн хугацаанд ТХН бүтэц орон тоо дутуу ажилласантай холбогдуулан ажлын үндсэн чиг үүрэг дээр удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын ажлууд нэмэгддэг тул баталсан орон тооны дагуу 14 хүнтэй ажиллах, ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн Зохицуулагч-хуулийн ажилтан, ЗУА-Санхүүгийн ажилтан, ХШҮ-БОННМА, ХАА-ны 3 ажилтан, ГХА нар болон 2 жолооч, 2 ОНА тус тус бие биеэ орлохоор зохион байгуулах, байгууллагын дотоод журамд шинэчлэн тусгах нь зүйтэй.

- Төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор төслөөс хийж буй томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалттай холбоотой засвар үйлчилгээ, урсгал зардлыг тусгай хамгаалалттай газруудын төсөвт жил бүр суулгаж, төслөөс хэрэгжүүлж буй бүхий л үйл ажиллагааг төсөл дууссаны дараа монголын тал буюу төсөл хэрэгжүүлэгчид бие даан авч явах нөхцөлийг бүрдүүлэх, төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж ажиллах нь зүйтэй.

- Төсөл хэрэгжүүлэгч БОАЖЯ болон ТХН-ийн хүний нөөцийн тогтворгүй байдал нь төслийн үйл ажиллагааны явц, тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх магадлалтай тул цаашид төслийн удирдлага, холбогдох ажилтан нарын ажлын байрны тогтвортой байдлыг анхаарах нь зүйтэй.

2.3. Эрсдэл үүсэх магадлал, тэдгээрийн төсөлд үзүүлэх нөлөө

Хүснэгт 2 Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөхөд анхаарах асуудал, санал зөвлөмж

№	Үйл ажиллагаа	Бэрхшээлтэй асуудал	Санал, зөвлөмж
1	Төслийн үйл ажиллагааг төлөвлөх, ажлын даалгавар, тендерийн бичиг баримт боловсруулахаас өмнө хэрэгцээ шаардлагыг үнэн бодитоор тооцоолох	БОАЖЯ, ХЗ, байгаль орчны газруудаас ирсэн хүсэлтүүдийн тоо хэмжээ их, урсгал зардал, төслөөс хойш тогтвортой байдлаа авч явах боломжгүй, тооцоололгүй хүсэлтүүд ирдэг	Төслийн орон нутаг дахь ажилтан нар төлөвлөгөө батлахаас өмнө буюу өмнө оны 11 дүгээр сард БО-ны газар, ХЗ, орон нутаг, ОБ-ийн байгууллагуудаас ирсэн хүсэлтийн дагуу судалгаа хийх, хэрэгцээ шаардлагыг БОАЖЯ-ны ТХГНБЗГ, СХОХ-тэй хамтран бодитоор тодорхойлох, төлөвлөгөөнд тусгуулах Төслийн хүрээнд нийлүүлсэн, БОАЖЯ-ны өмчлөлд шилжсэн тоног төхөөрөмжийн ашиглалт дээр БОАЖЯ-ны СХОХ-ээс хяналт тавих, хэрэгцээгүй эд хөрөнгийг шаардлагатай газар нь шилжүүлэх
2	Хэрэгцээ шаардлагын судалгаан дээр үндэслэн төслийн тухайн жилийн төсвийг бодитоор тооцоолох, төлөвлөх	ТХН-д мэргэжлийн төсөвчин, тэр чиглэлийн ажилтан байхгүй учир төлөвлөгөөнд тухайн ажлын төсвийг багцаалж суулгадаг	Нийлүүлэх тоног төхөөрөмжийн үнэ, зөвлөх үйлчилгээний зардал, үнэлэмжийн нарийн судалгаа, тооцооллыг урьдчилан хийсний дараа мэргэжлийн төсөвчингөөр хянуулж төсвийг төлөвлөх, төлөвлөгөөнд тусгах
3	Барилгын болон улирлын чанартай зөвлөх үйлчилгээний ажлуудын ажлын гүйцэтгэлд /хүйтний улирал зэрэг/ эрсдэлийг тооцож, бодит хугацаа тавих, мөн түүнчлэн ажил, тайлан хүлээн авах хугацааг тодорхой заасан график төлөвлөгөөгөөр баталгаажуулж оруулах	Төслийн 2023 оны ҮАТ-нд төлөвлөсөн барилгын ажлууд хэрэгжээгүй	Төслийн 2024 үйл ажиллагааны төлөвлөгөөнд барилгын ажлуудыг төлөвлөхдөө доорх асуудлыг анхаарах: Барилгын концепц үзэл баримтлал, ажлын даалгаврыг боловсруулсан байх, Барилгын ажлыг дулааны улиралд гүйцэтгэх нь барилгын чанарт шууд нөлөөлөх тул улирал харгалзаж төлөвлөх, Барилгын төсвийг инфляц, барилгын материал, шатахууны үнийн өсөлттэй уялдуулан бодитоор төлөвлөх, Санхүүжүүлэгч байгууллагаас зохих зөвшөөрлийг авах хугацааг тооцоолох, Барилгын мэргэжлийн зөвлөхийг авч ажиллуулах БОАЖЯ тухайн барилгын эзэмшил, ашиглалт, урсгал зардлыг хариуцан, төслийг тогтвортой байдлыг хангах

Хүснэгт 3 Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад анхаарах асуудал, санал зөвлөмж

№	Үйл ажиллагаа	Бэрхшээлтэй асуудал	Тайлбар/тодруулга	Санал, зөвлөмж	Холбогдох баримт бичиг
1	Үнэлгээний хороо байгуулах	БОАЖЯ-нд АЗ сертификаттай мэргэжилтэн дутмагаас үнэлгээний хорооны дарга нар, гишүүдийн давтамж их	Тайлангийн жил нийт 25 тендер төлөвлөсний 13 тендер буюу нийт ХАА-ны 52%-ийг нэг хүн даргалж байгаа давтамж нь БОАЖЯ-ны дарга, мэргэжилтэн нар АЗ гэрчилгээ дутмаг, ҮХ-нд ажиллахад ажлын ачаалал их, нэмэгдэл урамшуулал байхгүйтэй холбоотой тул яамны зүгээс албан хаагчдаа АЗ сургалтад суулгах шаардлагатай байна.	Захиалагч тал яамны дарга, мэргэжилтэн нараа АЗ сургалтад хамруулах, ингэхдээ удаа дараа тэнцээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох, Яамны мэргэжилтэн нар ажлын ачаалал их, үнэлгээний хороонд ажилласан урамшуулал, нэмэгдэлгүй тул мэргэжилтэн нарын урамшууллыг шийдвэрлэх боломжийг хайх	Төслийн хүрээнд 2023 онд гарсан тушаал шийдвэрийн ХШҮ
		ТББ-ын төлөөллийн давтамж их	Тайлангийн жил төслийн тендерийн үнэлгээний хороонд ТББ-ын төлөөлөл 4 удаа ажилласан 1 гишүүн, 3 удаа ажилласан 4 гишүүн, 2 удаа ажилласан 4 гишүүн байна.	Үнэлгээний хороонд ажиллах ТББ-ын төлөөллийг мэргэжил, үйл ажиллагааг нь харгалзан чиглэл чиглэлээр, эсвэл оноолтоор сонгосноор давтамжийг багасгах, солонгоруулах, ТББ-ын төлөөллийн урамшууллыг тендерийн бичиг баримтын үнээс шийдвэрлүүлэх	Тендерийн үнэлгээний хороонд ажилласан ТББ-ын гишүүдийн давтамж
		Тендер зохион байгуулалтын	Тайлангийн жил нийт 25 тендер төлөвлөснөөс 15 нь амжилттай	Зөвлөх багийн боловсруулсан үзэл баримтлал дээр үндэслэн ажлын	Төслийн хэрэгжээгүй ажлын

2	Сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангах, ажлын даалгавар боловсруулах, батлуулах	бэлтгэл ажил болох үзэл баримтлал, концепц хангагдаагүйгээс тендер зохион байгуулалт хойшилсон	зохион байгуулагдаж, 10 тендерийг зохион байгуулаагүй, 8 ажил 2024 он руу шилжин хэрэгжихээр болоод байна.	даалгавар, тендерийн бичиг баримт боловсруулахаас өмнө ТХН-ийн орон нутаг дахь ажилтан нар хэрэгцээ шаардлагын судалгааг гаргах, техникийн тодорхойлолт болон хуваарилалтыг захиалагч талаар батлуулсан байх, ажлын даалгавар, ТББ-ийн салшгүй, өөрчилшгүй хэсэг гэж зааж өгөх	ХШҮ /англи хэл дээр/
		ТХГН-ийн дэд бүтцийн /Байгаль хамгаалагчийн байр, нэвтрэх цэг, хяналтын цамхаг, хоноглох отоглох цэг гэх мэт/ батлагдсан стандарт байхгүй	Төслийн ҮАТ 4.02-т ТХГН-ийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дүрэм, журам, стандарт боловсруулах хэлэлцүүлэг хийх ажлыг төлөвлөсөн ч БОАЖЯ-наас чиглэл ирээгүйтэй холбогдуулан тус ажил 2024 он руу шилжсэн.	2024 онд төслийн дэмжлэгтэйгээр ТХГН-ийн журам, стандартыг боловсруулах, СХЗГ-аар батлуулах	
		Монгол-Германы Засгийн газар хоорондын буцалтгүй тусламжийн	Монгол Улсын ХАА-ны хуулийн дагуу бүх тендерийг цахимаар зохион байгуулахаар заасан хэдий ч төслийн хүрээнд зохион байгуулах гэрээ шууд байгуулах тендерүүд санхүүжүүлэгчийн		

3	Төслийн үндсэн бичиг баримтыг Монгол улсын хууль тогтоомжтой харьцуулан зөрчилдөх заалтуудыг тодорхойлж, санхүүжүүлэгч байгууллагад хүргүүлэх	хэлэлцээрийн хүрээнд хийгдсэн тусгай гэрээний заалтууд Монгол Улсад дагаж мөрдөгдөх зарим хуулийн заалтуудтай зөрчилдөж байдаг нь ажлын явцад саад учруулж байдаг.	ХАА-ны журмын дагуу tender.gov.mn-д оруулах боломжгүй байна.		
			ХАА-ны төлөвлөгөөг еврогоор төсөвлөхөд цахимд монгол улсын мөнгөн тэмдэгтээр төсвийг оруулдаг	Гэрээ байгуулах ханшийн зөрүүгээс болж төсөвт өртөг зөрөх буюу гэрээний үнийн дүн төсөвт өртгөөс илүү гараг магадлалтай	ХАА-ны төлөвлөгөөг евро болон төгрөгөөр баталж, зөрүү гарсан тохиолдолд тухай бүрд тохируулга хийж тухайн асуудлыг шийдвэрлэх боломжтой.
				Тус төслийн хэрэгжилтэд ХБНГУ-ын Засгийн газраас гаргах мөнгөн дүн нь еврогоор тооцогдсон бөгөөд сүүлийн жилүүдэд еврогийн ханш тогтвортой өссөн хэвээр байгаа нь төслийн санхүүжилтийн хувьд (гэрээлэгч нарт) давуу тал болох боломжтой.	

- Тайлангийн хугацаанд нийт 15 гэрээ шинээр байгуулагдсан бөгөөд нийт 5 гэрээ гэрээний хугацаандаа хэрэгжиж, гэрээг дүгнэсэн болно. Он дамжиж хэрэгжих нийт 8 гэрээнээс 3 гэрээний хугацаа сунгагдаад байна.

Хүснэгт 4 Гэрээний хэрэгжилтэд анхаарах асуудал, санал зөвлөмж

№	Анхаарах асуудал	Бэрхшээлтэй асуудал	Санал, зөвлөмж
1	Гэрээг байгуулахдаа барилгын ажлыг Засгийн газрын 160 дугаар тогтоол, бусад ажил, бараа бүтээгдэхүүнийг Сангийн сайдын 193 журмын хавсралт сангийн сайдын 4 дүгээр журам (Сангийн сайдын 4 дүгээр журмаар шинэчлэгдсэн)-ын дагуу тус тус хүлээн авах	Гэрээлэгч байгууллагууд гүйцэтгэлийг өөр өөр загвараар гаргаж ирдэг тул ажлыг хүлээн авах, санхүүжилтийг олгох ажил буцах, удаашрах зэрэг асуудлууд гардаг.	Засгийн газраас Төлбөрийн нөхцөлийн дагуу төлбөр гарах тус бүр дээр ямар ямар акт, тайлан, бичиг баримт бүрдүүлэхийг зааж өгөх, гэрээг байгуулахдаа гүйцэтгэлийн маягт, хүлээн авах актын загваруудыг гэрээнд хавсаргах
2	Гэрээг байгуулахдаа ажлын даалгаврыг гэрээний хавсралтаар биш заалтаар оруулахыг БОАЖЯ-ны СХОХ-ээс удаа дараа анхааруулсан	Гэрээний загвар нь ГСБЗ (KfW) банкны загварын дагуу хийгддэг тул захиалагч талын гэрээний загвараас өөр байдаг.	Захиалагч талын шаардаж буй шаардлагыг ГСБЗ (KfW) банканд мэдэгдэж, хариуг захиалагч талд албан ёсоор хүргүүлэх
3	Тавилга, IT тоног төхөөрөмжүүдийн хүргэлт, ашиглалт болон суурилуулалтын сургалтуудыг хийх		Гэрээг байгуулахдаа хүргэлт, суурилуулалт болон холбогдох сургалтыг гэрээлэгч талаар гүйцэтгүүлэхээр оруулж өгөх
4	Гэрээг байгуулахдаа гардуулах болон нээлтийн ёслолын ажиллагааны зохион байгуулалтыг гэрээлэгч талаар гүйцэтгүүлэхээр оруулж өгөх	Барилга, автомашин, техник, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт дээр яамнаас ёслолын ажиллагаа зохион байгуулахыг шаарддаг ч “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-тай холбогдуулан Сангийн яамнаас зардлыг зөвшөөрөхгүй.	Олон улсын төсөл хөтөлбөрийн хувьд гэрээлэгч нараас гардуулах болон нээлтийн ёслолын ажиллагааны зардлыг гаргуулах нь зохимжгүй, гэрээд ажлын гүйцэтгэлтэй сурталчилгааны ажил хамааралгүй тул ТХН-ийн урсгал зардалд төсөвлөх
5	ОХУ болон Украин улс хоорондын дайнтай холбогдуулан KfW банкнаас тавьсан	Төслийн I шатны хүрээнд “ТХГН-ийн ОБ-ийн сумдыг эмнэлгийн түргэн тусламжийн машинаар хангах” ажлын	ОХУ-д үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх боломжгүй тухай гэрээлэгч нарт урьдчилан мэдэгдэх

	шаардлагын дагуу ОХУ-аас бараа бүтээгдэхүүн нийлүүлэхгүй байхад анхаарах	хүрээнд УАЗ машинууд нийлүүлсэн нь II, III шатанд боломжгүй болсон.	
6	Төслийн хүрээнд байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээний дугаар өөр өөр	MONNCB-05/2023, MONNCB-БОЯБХУАӨДЗТөсөл/ БОЯБХУАӨДЗТөсөл/ 202301006 23/161, 23/249	Гэрээг байгуулахдаа тендерийн дугаар, гэрээний дугаарыг ялгаж өгөх, кодын дагуу, ижил байх, яамнаас өгсөн дугаарыг баримтлах
7	Гэрээг сунгасан, ажлын даалгаварт өөрчлөлт орсон тохиолдолд бүх өөрчлөлт, шийдвэрийг мэдэгдэх ёстой журмын дагуу KfW банканд мэдэгдэх	Тайлангийн хугацаанд нийт 3 гэрээний хугацааг сунгаснаар төлөвлөгөөт хугацаандаа хэрэгжээгүй	Баталсан ажлын даалгаварт түгээлтийн жагсаалтад ямар нэгэн өөрчлөлт орохоор бол KfW-аас үл татгалзах авна гэж 2023 оны явцын үнэлгээний хурлын тэмдэглэлд заасныг анхаарч ажиллах
8	Төслийн хэмжээнд боловсруулагдаж буй албан бичиг, ажлын даалгавар (хөрөнгө оруулалтын хуваарилалт), тендерийн баримт бичиг, тушаал шийдвэр, гэрээ зэрэг албаны баримт бичгийн боловсруулалтад хуулийн этгээдийн нэршлийг товчлолгүй, бүрэн бүтнээр бичиж хэвших	Дорнод УТХГ-ын ХЗ гэж бичсэнийг Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргаа гэж бичих, Их нартын БНГ-ын ХЗ гэснийг Их нартын байгалийн нөөц газрын хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэгч "Их нартын менежмент" ТББ гэх мэт	Төслийн Захиргаа удирдлагын ажилтан БОАЖЯ-ны яамны ТХГНБЗГ, ГХАХ-тэй холбогдон яамны газар хэлтсийн болон харья байгууллагын албан ёсны нэрийг англи монголоор авч, ТХН-ийн ажилтан нарт тухай бүр мэдээлэх, өөрчлөлт гарсан тохиолдолд шинэчлэх
9	Гэрээг байгуулахдаа тухайн ажлыг KfW банканд тайлагнах, тусдаа ажлын хэсэг байгуулж хүлээн авах, зөвшөөрөл авах, санхүүжүүлэгч банканд тайлагнах тохиолдолд гэрээний хугацааг бодитоор тооцоолох	Орчны бүсийн зээлийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний ажлын гэрээг 2023 оны 08 дугаар сард 2 сарын хугацаатай хийгдсэн хэдий ч 6 сар үргэлжилж байна.	Төслийн 1 үе шатанд Орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор хэрэгжүүлсэн тухайн ажлын үнэлгээнээс шалтгаалан төслийн II, III шатанд хэрэгжүүлэх ОБЗЭС-ийн ажил шийдвэрлэгдэх тул онцгой анхаарч ажиллах

№	Гэрээний нэр	Гэрээний хугацаа	Сунгасан хугацаа	Сунгасан үндэслэл	Цаашид анхаарах асуудал, санал зөвлөмж
1	БОНУ-ний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулахад дэмжлэг үзүүлэх	2023.08.10-2023.10.09	1 сараар 2023.11.08	Захиалагчаас ирүүлсэн чиглэлийн дагуу	Гэрээг байгуулахдаа цар тахлын болон дайны зэрэг давагдашгүй хүчин зүйлийг урьдчилан тооцоолж, валютын ханшны өсөлт уналт зэрэг эрсдэлийг тооцож, гэрээний хугацаа, үнийг бодитоор төлөвлөх
2	БО-ны байгууллагууд бусад ТХГН-ийн ХЗ-дын ажилтнуудыг 4 улирлын дүрэмт хувцсаар хангах	2022.12.30-2023.06.30	2 сараар 2023.08.28	Захиалагчаас ирүүлсэн чиглэлийн дагуу (размер өөрчлөгдсөн)	
3	ОБЗЭС-гийн үйл ажиллагааг өргөтгөн хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээ	2023.08.10-2023.11.08	2 сараар 2024.01.15	ЗБ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу	

• Тайлангийн хугацаанд төслийн танилцуулга материал, үндсэн бичиг баримт, хэлэлцээр, санамж бичиг, удирдах хорооны шийдвэр, төсөв, бүрэлдэхүүн хэсэг, шалгуур үзүүлэлт, төслийн үйл ажиллагааны болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төслийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, хяналт шинжилгээ, аудитын тайлан, төслийн хүрээнд зарласан тендерийн зар, холбогдох баримт бичгүүд, төслийн хүрээнд байгуулсан гэрээ, явцын гүйцэтгэл, тайлан, ажил хүлээн авсан акт, санхүүжилт болон татварын хөнгөлөлтөд шаардлагатай бусад бичиг баримт, төслийн хүрээнд хийгдэж буй хэрэгцээ шаардлагын болон суурь судалгаа, сургалтын тайлан, төслийн үйл явдлын мэдээ зэрэг бүхий л шаардлагатай мэдээ, мэдээллийг “Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн нэгдсэн сан” цахим системд <https://odamis.mof.gov.mn> Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://www.tender.gov.mn/mn/index/> Шилэн дансны мэдээлэл <https://shilendans.gov.mn/> Байгаль орчны статистикийн мэдээллийн сан <https://www.eic.mn/box/> БОЯБХУАӨДЗ төслийн цахим хуудас <http://www.baccp.mn/> фэйсбүүкд ВАССР хаягаар тус тус байршуулан ажиллав.

Хүснэгт 6 Төслийн ХШҮ, ил тод байдал

Үйл ажиллагаа	Бэрхшээлтэй асуудал	Тайлбар/тодруулга	Санал, зөвлөмж
Тендерийг цахимаар зохион байгуулах	Монгол Улсын ХАА-ны хуулийн дагуу бүх тендерийг цахимаар зохион байгуулахаар заасан хэдий ч төслийн хүрээнд зохион байгуулах гэрээ шууд байгуулах тендерүүд санхүүжүүлэгчийн ХАА-ны журмын дагуу tender.gov.mn-д оруулах боломжгүй байна.	Төслийн худалдан авалтын ажил нь БОАЖЯ болон Германы Сэргээн босголт зээлийн банк (KfW) хооронд байгуулсан Тусгай гэрээний Хавсралт 3, 4 болох “Санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд хөгжиж буй орнуудад бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам”-ны дагуу явагддаг	Төслийн хүрээнд зарлагдах гэрээ шууд байгуулах тендерүүд tender.gov.mn-ээр бус олон нийтийн хэвлэл, яамны болон байгууллагын цахим хуудсаар зарлах нь тендерт оролцох хүсэлтэй байгууллагад хүрдэггүй тул оролцогчдын тоо хязгаарлагдмал, өрсөлдөөн бага учир дутагдалтай байгаа тул Төрийн ХАА-ны газраас зөвлөгөө авч, tender.gov.mn-ээр зарлах боломжийг эрэлхийлэх
Төслийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах	Төслийн bassr.mn цахим хуудас 2022 оноос хойш алдаа зааж байсан.	Тайлангийн жил төслийн цахим хуудсыг шинэчлэх, мониторингийн мэдээллийн сан байгуулах ажлын гэрээг байгуулж ажилласны дүнд цахим хуудсыг шинэчлэх ажлыг эхлүүлээд байна.	Төслийн үйл ажиллагааг цахимаар сурталчлах ажлыг идэвхжүүлэх, төслийн захиргаа, удирдлагын ажилтан цахим хуудасны ажиллагааг хянаж, мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж ажиллах
	Төслийн хөрөнгө оруулалтыг гардуулах арга хэмжээ, ёслолын ажиллагаа, бэлэг дурсгалын зүйл, төслийн танилцуулга, хавтас хэвлэх зардал төсөвт суугаагүй	Санхүүжүүлэгч байгууллага болох ГСБЗ(KfW) банкныг ялангуяа орон нутагт ГХАОУН (GIZ-тай) андуурах тохиолдол гарч байна.	“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-тай холбогдуулан зар, шуудан, хэвлэлт болон шаардлагатай томилолтын зардлыг хэмнэсэн бусад зардлаас /ж-нь: ТХН орон тоо дутуу ажилласан тул цалингийн хэмнэлт, 3 томилолтын удирдамжийг гаргасан ч ТХН-ээс оролцоогүй зэрэг томилолтын зардлын хэмнэлт/ санхүүжүүлэх боломжийг эрэлхийлэх

Тендерийн оролцогч нар гомдол гаргах		Тендерийн оролцогч “МБ Инженеринг” ХХК, “Медимпекс” ХХК нь гомдлыг Санхүүжүүлэгч байгууллага ХБНГУ- дахь ГСБЗ(KfW) Банк, МУ-д суугаа ХБНГУ-ын ЭСЯ-руу илгээсэн.	Гомдлыг хүлээн авах хаягийг ТББ-ийг боловсруулахдаа тодорхой зааж өгөх
Төслийн хүрээнд зохион байгуулагдсан тендерийг шалгах	Төслийн ТББ-ийг орчуулах зардал төсөвт суугаагүй тул ТХН-ийн ХАА-ны ажилтан нар өөрсдөө орчуулдаг	Төслийн хүрээнд хийгдсэн тендерүүдийг санхүүжүүлэгч байгууллагаас сонгож шалгадагтай холбогдуулан ХАА-ны ажилтан нар өөр өөрсдийн ТББ-ийг орчуулж, ГСБЗБ-нд илгээдэг.	2024 оны төлөвлөгөөнд орчуулгын зардлыг суулгаж, тендерийн бичиг баримтаас гадна төслийн үндсэн бичиг баримт, цахим хуудасны мэдээлэл зэргийг албан ёсны орчуулгын газраар гүйцэтгүүлэх
Төслийн ажлуудын гүйцэтгэлд газар дээр нь хяналт тавих, хяналт хийх, орон нутагт томилолтоор ажиллах	ХШҮ-ний 2023 оны төлөвлөгөөний дагуу орон нутагт ажиллах нийт 4 ажлыг төлөвлөсний дагуу удирдамжууд боловсруулж батлуулсан. Үүнээс: Төслийн I шат /Төвийн бүс/, II шат /Баруун бүс/-ийн үйл ажиллагаатай танилцах /2023.06.28/, Нөмрөг болон Дарьгангын ДЦГ-уудад ажиллах /2023.10.03/ томилолтууд хэрэгжсэн.	Төслийн I шатны хүрээнд хэрэгжүүлж буй ОБ-ийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх /2023.07.20/, Их газрын чулуу, Говь гурван сайхан, Их Богдын БЦГ болон Говийн Их, Говийн бага ДЦГ томилолтоор ажиллахад /2023.10.04/ ТХН оролцоогүй.	Төслийн I шаттай харьцуулахад төслийн II, III шатанд Ховд аймагт Зөвлөх баг болон ТХН-ийн орон нутаг хариуцсан ажилтан, Увс аймагт Орон нутгийн зохицуулагч нар суурин ажилладаг давуу талыг ашиглан газар дээр нь ХШҮ хийх ажлыг эрчимжүүлэх, Өгсөн хөрөнгийн үр дүнг тооцох судалгаа, асуумж, үр дүнг тооцдог аргачлалыг тодорхойлох Томилолтын төсвийг ирэх оны төлөвлөгөөнд хангалттай суулгах
		Төслийн мониторинг үнэлгээний журам, аргачлалыг (DAC) буюу хөгжлийн шалгуур үзүүлэлт, KfW банкны журмын дагуу боловсруулах, төслийн үр дүн,	Энэхүү мониторинг үнэлгээний аргачлал нь төслийг хэрэгжүүлэгч талуудад ихээхэн ач холбогдолтой бөгөөд Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн хяналт, үнэлгээ хариуцсан ажилтан

		бүтээгдэхүүний багцын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийг хэмжих тоон болон чанарын хэмжигдэхүүнийг шинээр тодорхойлох, Төслийн үнэлгээ, мониторингийн журам, аргачлалыг боловсруулж, төслийн Үр дүнд суурилсан мониторинг (RBM), үнэлгээний системийг Дэлхийн Банкны үр дүнд суурилсан үнэлгээ, мониторингийн систэмд нийцүүлэн 7 үе шаттай аргачлалаар явцын болон нөлөөллийн мониторинг үнэлгээг хийхээр эцэслэн боловсруулаад байна.	болон орон нутгийн ажилтнуудад чадавхжуулах сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна.
Шилэн дансны хэрэгжилтэд ХШҮ хийх	Шилэн дансны хэрэгжилтэд ХШҮ хийхэд тайлангийн хугацаанд доорх алдаа зөрчлүүд гарсан байна. Үүнд: Төсөв гүйцэтгэлийн чиглэлээр “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл”-ийн мэдээг 1 удаа хоцорч оруулсан, 1 удаа тайлангийн хугацааг 3 хоногоор сунгасан бөгөөд 2023 оны 11 дүгээр сард тухайн онд байгуулсан өмнөх саруудын гэрээг бөөндөж оруулсан байна. Дараа жилийн төсвийн төсөөлөл”-д мэдээг мөн 1 удаа хугацаа хоцорч оруулсан байна. Харин хөрөнгө оруулалт, тендерийн чиглэлээр “Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл”-д т1 удаа тайлангийн хугацааг 21 хоногоор сунгасан бол бусад чиглэлд багтах “Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан”-г хоцорч ил тод болгосон байна. ХАА-ны төлөвлөгөө болон тайланг оны 01 дүгээр сарын 10-ны дотор оруулах ёстой /хугацаандаа хэдий ч оруулах мэдээлэл байхгүй гэж төлөвлөгөө, тайланг оруулсан байна.	Шилэн дансны мэдээллийн санд төсөв-гүйцэтгэл, хөрөнгө оруулалт-тендер, бусад гэсэн 3 чиглэлийн дагуу нийт 24 мэдээ оруулахаас 8 нь тухай бүр, 5 нь сар бүр, 4 нь хагас жил, 7 нь жил тутам оруулах мэдээ байдаг. Үүнээс ТХН-ийн санхүүгийн ажилтан 15 мэдээг оруулдаг бол ХАА нар 9 мэдээ оруулдаг бөгөөд бүгд хуулийн хугацаатай тул мэдээг цаг хугацаанд нь оруулж, ил тод байдлын хэрэгжилтийг хангаж ажиллах “Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн мэдээ нь гэрээний мэдээлэл тул ГХА хариуцаж оруулах зэрэг болно.	

• Төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор төслөөс хийж буй томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалттай холбоотой засвар үйлчилгээ, урсгал зардлыг тусгай хамгаалалттай газруудын төсөвт жил бүр суулгаж, төслөөс хэрэгжүүлж буй бүхий л үйл ажиллагааг төсөл дууссаны дараа монголын тал буюу төсөл хэрэгжүүлэгчид бие даан авч явах нөхцөлийг бүрдүүлэх, төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах нь чухал байна. Төслийн тогтвортой байдлын хангах дээрх зорилгоор ТХН 2023 оны 05 дугаар сард Архангай, Өвөрхангай, Дундговь, Өмнөговь аймгийн тусгай хамгаалалттай газруудад тус тус ажиллаж, төслийн хүрээнд ХЗ-нд оруулсан хөрөнгө оруулалтад тооллого хийж, хөрөнгө оруулалтын ашиглалт хамгаалал, үр ашигт байдалд үнэлгээ хийсний дагуу доорх зөрчлийг илрүүлж арга хэмжээ авч ажилласан.

Хүснэгт 7 Орон нутагт хийсэн ХШҮ-ээр илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ, зөвлөмж

№	Илрүүлсэн зөрчил	Авсан арга хэмжээ	Цаашид анхаарах асуудал	Зөвлөмж
1	Хангайн бүсийн СМТ-ийг барьж байнгын ашиглалтад 2018 оны 09 дүгээр сард Хангайн нурууны БЦГ-ын ХЗ-нд хүлээлгэн өгсөн хэдий ч, Хангайн бүсийн төвийн үйл ажиллагааны болон урсгал зардлыг 5 жилийн турш төсөвт суулгаагүй.	Төслийн 2023 оны 10 дугаар сарын 18-ны 94/23 дугаартай “Арга хэмжээ авах тухай” албан мэдэгдлийг томилолтоор ажилласан тухай тайлан, хурлын тэмдэглэл, холбогдох бичиг баримтыг хамт БОАЖЯ-нд хүргүүлсэн.	Төслөөс санхүүжүүлж барьсан тус бүсийн төвийг зорилго зорилтын дагуу бус, зөвхөн Хангайн нурууны хамгаалалтын захиргааны байраар ашиглаж, бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулаагүйгээс шалтгаалан дараа дараагийн бүсийн төвийг төслийн хүрээнд барих боломжгүй, үр дүнгүй гэж санхүүжүүлэгч байгууллага болох ГСБЗБ (KfW) банк 2023 оны 05 дугаар сард хийсэн төслийн явцын үнэлгээний үеэр илэрхийлсэн.	Төслийн хүрээнд хүлээлгэн өгсөн эд хөрөнгийг бүртгэх, ашиглах, тайлагнах, хяналт тавих, хариуцлага тооцох болон бусад харилцааг “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах” Сангийн сайдын 131 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу холбогдох төрийн захиргааны төв байгууллага хариуцан ажиллана. Иймд БОАЖЯ-ны ТХГНБЗГ, СХОХ тус асуудлуудыг анхаарч, 2024 оны төсөвт Бүсийн төвийн үйл ажиллагааны зардлыг суулгаж батлуулах, төслөөс олгосон хөрөнгө оруулалтын ашиглалтад хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.
2	Хорго Тэрхийн БЦГ-т баригдсан бүхий худалдааны цэгийг 2020 онд хүлээлгэн өгснийг өнөөдрийг хүртэл төрийн өмчид бүртгүүлээгүй	Төслийн 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 88/23 дугаартай “Өмч хөрөнгөд бүртгэх тухай” албан бичгээр БОАЖЯ-нд хүргүүлсэн.		
3	Хангайн бүсийн СМТ-ийн үзмэрийн танхим, дагалдах техник тоног төхөөрөмжийг төрийн өмчид бүртгэх бүртгэл зөрүүтэй	ҮТА №06/2020 дугаартай гэрээний дагуу зарлагын баримт, холбогдох бичиг баримтыг хангайн нурууны БЦГ-ын ХЗ-нд илгээсэн. /2023.10.05/		

3. ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ХЭРЭГЛЭСЭН АРГА ЗҮЙ, СУЛ ТАЛ

Хяналт-шинжилгээ нь хөтөлбөр, төслийн хэрэгжилт нь төлөвлөлтийн дагуу явж байна уу гэдгийг шалгахад тусалдаг бол үнэлгээ нь үйл ажиллагааг хэрэгжүүлснээр үр дүнд хүрсэн эсэхийг тодорхойлох үүрэгтэй “үр дүнг тооцох” шинжилгээ юм.

Тайлангийн хугацаанд төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл явцыг сайжруулах, шалгуур үзүүлэлтийг боловсруулах зорилгоор төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцоог шинэчлэн боловсруулсан. (Хүснэгт 8-аас үзнэ үү.)

Тус тогтолцоо нь ТХН-ийн ажилтан, зөвлөх багийн үүрэг хариуцлага, ажлын хуваарилалт, үйл ажиллагааны явцын мэдээ бүрэн харагддагаараа давуу талтай. Сул тал нь үнэлгээнд үр дүнгээс гадна чанарын буюу үр ашигт байдлыг тооцохгүй, зөвхөн гүйцэтгэлийг суурь болгодог тул үр ашигт байдлыг гаргаж ирэх тал дээр дутагдалтай. Үнэлгээний аргачлалыг боловсруулахдаа мөн ажлыг үе шат бүрээр нарийвчлан, үйл ажиллагааны шат дараалал бүрийг орхигдуулалгүй оруулахыг хичээж, хийгдэх ажлын тоо хэмжээ, ачаалал, зарцуулах хугацаа зэргийг харгалзан тооцож, үнэлгээнд эзлэх хувийг бодитой гаргахыг зорьсон болно. Үүнд:

Үнэлгээг хийхдээ үйл ажиллагааны үндсэн гурван чиглэлээр хийнэ.

Нэг. Төслийн худалдан авах ажиллагааны бэлтгэл ажлыг үнэлэх. Хэрэгцээ шаардлагын судалгаа, үзэл баримтлал, концепц гаргах болон техникийн тодорхойлолт, хуваарилалтын хүснэгтийг боловсруулах, батлуулах гэсэн үе шаттай.

Хоёр. Төслийн худалдан авах ажиллагааны явцыг үнэлэх. Худалдан авах ажиллагааны нийт 15 үе шатыг тус бүрийг тодорхойлсон тул бодит үнэлгээ гарсан гэж үзэж байна. Гэрээ байгуулснаар тус ажлыг 100% гүйцэтгэлтэй гэж үзнэ./

Гурав. Төслийн гэрээний хэрэгжилтийг үнэлэх. Гэрээний хэрэгжилтийг гэрээний гүйцэтгэлийн дагуу олгох санхүүжилтийн хуваарийн дагуу үнэлэгдэнэ. /Гэрээг дүгнэснээр тус ажлыг 100% гүйцэтгэлтэй гэж үзнэ. Энэхүү үнэлгээнд Худалдан авах ажиллагаа 60%-ийг эзлэхээр тооцоолсон./

Үнэлгээний оноог өгөхдөө Засгийн газрын хяналт, шинжилгээ үнэлгээний аргачлалыг суурь болгон энгийн арифметик арга ашиглан тооцов.

Хүснэгт 8 Үнэлгээний аргачлал, үнэлгээний хүснэгт

Д/д	Үйл ажиллагаа	Ажлын төлөвлөгөөт хугацаа, үр дүн	Ажил, тендер ийн төрөл	Ажлын нарийвчилсан явц, тэдгээрийн үнэлгээ																							ХШҮ																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																										
				Тендерийн нөхцөл байдал, хариуцсан ажилтан		Бэлтгэл ажил/ Ажлын даалгавар	Зөвлөх баг, ОНА, холбогдох ажилтан нар	(I) %	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт															(II) %	Гэрээний гүйцэтгэл							(III) %	Нэмэлт шаардлагатай ажил						(I+II+III)%																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																														
				Тендерийн нөхцөл байдал, хариуцсан ажилтан					Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт																Гэрээний гүйцэтгэл								Нэмэлт шаардлагатай ажил																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																				
				1	2				1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15		1	2		3	4	5	6		7	8	9	10	11	12		13	1	2	3	4	5	6																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																							
%				Хэрэгцээ шаардлагын судалгаа, үзэл баримтлал, концепц гаргах	Техникийн тодорхойлолт, хуваарилалтын хүснэгтийг боловсруулах, батлуулах /ТТ болон хуваарилалт нь ажлын даалгаврын өөрчлөшгүй, салшгүй хэсэг байна./	Бэлтгэл ажлын гүйцэтгэл техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг батлуулснаар үнэлэгдэнэ	Ажлын даалгаврыг батлуулах	Үнэлгээний хороо байгуулах, тушаал батлуулах	Үнэлгээний хорооны 01 хурал хийх, үнэлгээний хороонд ажиллах мэдүүлэг бөглөх, тендерийн баримт бичгийн төслийг боловсруулах	KfW банкнаас NOL авах	Тендерийн баримт бичгийг батлуулах	Тендерийг зарлах	Тендер хүлээн авах	Тендер нээх, үнэлгээний хорооны 02 хурал, ашиг сонирхолын мэдүүлэг бөглүүлэх	Үнэлгээний хорооны хурал хийх, тендерийн үнэлгээ хийх	KfW банк руу тендерийн үнэлгээний тайланг хүргүүлэх, танилцуулах, батлуулах	KfW-ийн баталсан тендерийн үнэлгээний тайлан, зөвлөмжийг захиалагчид танилцуулах, мэдэгдэл боловсруулах, албажуулах, хүргүүлэх	tender.gov.mn-д үр дүн нийтлэх	Гэрээний төслийг боловсруулах, гэрээлэгч талд хүргүүлэх	Гэрээний өмнөх уулзалтыг зохион байгуулах, хурлын тэмдэглэлийг албажуулах	Гэрээ байгуулах, албажуулах, холбогдох талуудад хүлээлгэн өгөх	Тендер зохион байгуулалтын гүйцэтгэл гэрээ байгуулалснаар үнэлэгдэнэ	Төслийн гүйцэтгэлд эзлэх хувь	Гэрээний өмнөх уулзалт	Талуудыг шаардлагатай мэдээллээр хангах	Эхний санхүүжилт гаргах бичиг баримтын хүлээн авах, хянах, албажуулах, санхүүгийн ажилтанд хүлээлгэн өгөх	Эхний санхүүжилтийг олгох	Татвараас чөлөөтүүлэх бичиг баримтын хүлээн авах, хянах, санхүүгийн ажилтанд хүлээлгэн өгөх	Татвараас чөлөөтүүлэх	Ажлын хэсгээр ажлыг хүлээн авах	Ашиглагч байгууллагуудад хүлээлгэн өгөх, актыг албажуулах	Гүйцэтгэлийн баталгааг цуцалж, чанарын баталгааг гаргуулах	Гэрээг дүгнэх, актыг албажуулах	Сүүлийн санхүүжилт гаргах бичиг баримтын хүлээн авах, хянах, албажуулах, санхүүгийн ажилтанд хүлээлгэн өгөх	Сүүлийн санхүүжилтийг олгох	Өмч хуваарилах бүртгэх тухай мэдэгдлийг захиалагч талд хүргүүлэх	Гэрээний биелэлт сүүлийн санхүүжилт олгосноор үнэлэгдэнэ	Гэрээний нөхцөл байдал, хариуцсан ажилтан	Еслолын ажиллагаа зохион байгуулах	Гомдол шийдвэрлэх, хяналт тавих, хүлээлгэн өгөх зэрэг асуудлаар томилолтоор ажиллах	Тайланг БОЯБ-ын зөвлөлөөр хэлэлцүүлэх	Гэрээг сунгасан байдал, давтамж	Тайланг цахим хуудаснаа байршуулах	Хөрөнгийг ТӨБЗГ-аар тогтоол гаргуулж өмчид бүртгүүлэх	Нийт биелэлт бэлтгэл ажил, тендер, гэрээний биелэлтийн дундажаар үнэлэгдэнэ	Биелэлт	Тайлбар, зөвлөмж, авах арга хэмжээ																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																						
50																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																					

4. ҮНЭЛГЭЭ

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хувьд тухайн жилдээ Үйл ажиллагааны төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гэж тус тусад нь төлөвлөн, төслийн удирдах хороогоор хэлэлцүүлэн батлуулдаг.

Төслийн 2023 оны үйл ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөөний дагуу нийт 58 ажил төлөвлөснөөс ТХН-ийн дотоод 4 ажлыг үнэлээгүй тул нийт 54 ажил.

Нийт 54 ажлаас ТХН-ийн үйл ажиллагаанаас үл хамаарах шалтгаанаар хэрэгжээгүй 5 ажлыг үнэлээгүй. Үүнд:

1. Төслийн барилгын хяналт, 2. Эрээн нуурыг сэргээх, 3. Хуулийн нэмэлт өөрчлөлтийн хэлэлцүүлэг хийх, 4. Олон улсын туршлага судлах, 5. Хяналт, үнэлгээний мониторингийн сургалт хийх зэрэг ажлууд болно.

Хүснэгт 9 Төслийн хэмжээнд 2023 онд төлөвлөсөн нийт ажлын гүйцэтгэл



Үнэлсэн: Нийт 49 ажил.

100%-тай=30=3000 /үр дүнтэй, бүрэн хэрэгжиж дууссан/

70%-тай=7=490 /гэрээ хэрэгжих шатандаа, өөрсдөөс хамаарах шийдвэр гарсан/

50%-тай=4=200 /боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, гэрээ байгуулагдах шатандаа/

30%-тай=1=30 /боловсруулалтын шатандаа гэрээ байгуулагдах шатандаа/

7 ажил =0 /хийгдээгүй/

Үүнд: Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн санхүүжилт гаргах 2 ажил, Баруун бүсийн төвийн барилгын концепц боловсруулах болон зураг төсөв гаргах 2 ажил, Говийн их ДЦГ-ын хамгаалалтын захиргааны байр барих 1 ажил, Байгаль хамгаалагчийн байр барих 2 ажил зэрэг хэрэгжээгүй болно.

БОЯБХУАӨДЗ төслийн II,III шатны үйл ажиллагааны хэрэгжилт 2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар арифметик дунджаар 75.9 %-ийн биелэлттэй байна.

Хүснэгт 10 Төслийн хэмжээнд 2023 онд төлөвлөсөн нийт ажлуудыг төслийн бүрэлдэхүүн хэсгээр гүйцэтгэл

Төслийн II, III шат			
Үйл ажиллагааны хэсгүүд	Ажлын тоо	Үнэлгээ %	Тайлбар
Төслийн ерөнхий менежмент	6	100	Нийт 6 ажил: 6 ажил 100%
Бүрэлдэхүүн хэсэг 1	10	72.2	Нийт 10 ажил: 4 ажил 100%, 1 ажил 70%, 3 ажил 50%, 1 ажил 30%, 1 ажил үнэлэхгүй
Бүрэлдэхүүн хэсэг 2	17	65	Нийт 17 ажил: 9 ажил 100%, 2 ажил 70%, 5 ажил 0%, 1 ажил үнэлэхгүй
Бүрэлдэхүүн хэсэг 3	9	74.4	Нийт 9 ажил: 6 ажил 100%, 1 ажил 70%, 2 ажил 0%
Бүрэлдэхүүн хэсэг 4	7	78	Нийт 7 ажил: 2 ажил 100%, 2 ажил 70 %, 1 ажил 50%, 2 ажил үнэлэхгүй
БОННМ, Мониторинг	5	92.5	Нийт 5 ажил: 3 ажил 100%, 1 ажил 70%, 1 ажил үнэлэхгүй
Төсөл хэрэгжүүлэх нэгж зөвлөх багийн зардал	4	50	ТХН-ийн дотоод 4 ажлыг үнэлээгүй
Дүн	58	75.9	

Тус төсөл нь Санхүүгийн хамтын ажиллагааны төсөл учир техникийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөртэй харьцуулахад бодит хөрөнгө оруулалт хийдэг онцлог юм. Иймээс ч төслийн хэрэгжилтэд худалдан авах ажиллагаа үйл ажиллагаанд, тэдгээрээс үүдэлтэй гэрээний хэрэгжилт, холбогдох үйл ажиллагаатай үр дүн нь шууд холбоотой.

Хүснэгт 11 Төслийн хэмжээнд төлөвлөсөн ХАА, тэдгээрийн гүйцэтгэл



4.1. Өнөөгийн хэрэгцээтэй тохирч буй байдал буюу хамааралтай байдал

Одоогийн байдлаар нийт нутгийн 21 хувь буюу 32,8 сая га талбай бүхий 120 тусгай хамгаалалттай газар байна. Эдгээр газрууд нь 35 нь улс, 4 нь төр, хувийн хэвшлийн хамтын менежментээр хамгаалалтын захиргаанд хуваагдаж ажиллаж, нийт 39 хамгаалалтын захиргаад хамгааллын менежментийн төлөвлөгөөг олон улсын (open standard) аргачлалаар боловсруулж байгаль орчны багц хууль, тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ТХГН-ийн хүрээнд хэрэгжүүлж буй бүхий л үйл ажиллагаа, хүчин чармайлтын дүнд чамлахааргүй амжилтад хүрч байгаа боловч сорилт, бэрхшээлүүд байсаар байна. Олон нийтийн экологийн мэдлэг, мэдээлэл дутмаг байдгаас зүйлийн тоо буурсан байна. Түүнчлэн:

- (i) хамгаалалтын түвшин хэтэрхий сул,
- (ii) тусгай хамгаалалттай нутгийн нэгдмэл байдлыг харгалзан үздэггүй,
- (iii) байгаль хамгаалагчид, хамгаалалттай нутгуудад ажиллах ажилчдын тоо, тэдгээрийн боломж бололцоо хангалтгүй зэргээс шалтгаалан тусгай хамгаалалттай нутгийн хамгаалалтын байдал шаардлага хангаж чадахгүй байна.

Иймд Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг (орчны бүс болон экологийн коридор) бэхжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүс дэх орон нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих тус төсөл нь цаг үеэ олсон, чухал ач холбогдол бүхий төсөл юм.

Төслийн II, III шат хэрэгжих Баруун болон Говийн бүсийн ТХГН-ийн биологийн олон янз байдлыг хамгаалах, ой болон бэлчээрийн тогтвортой байдлыг хангах, хамгаалалтын захиргаануудын менежментийг сайжруулах, тэдгээрийн орчны бүсийн дэд бүтэц, иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлийн хөрөнгө оруулалтууд нэмэгдэж байна.

4.2. Төслийн хүлээгдэж буй үр нөлөө

Төслийн үндсэн баримт бичигт тусгагдсанаар төслийн үр нөлөөллийн дараах дөрвөн үндсэн шалгуур тавигдсан. Үр нөлөө нь хамгаалж буй БОЯБ-ын тоо хэмжээний өсөлт бууралт, үйл ажиллагааны тогтвортой байдал, иргэдийн байгаль хамгааллын мэдлэг, чадварын өсөлт, судалгааны давтамж, удирдлагын боловсронгуй байдлаар илэрнэ. Үүнд:

1. Менежментийн үр ашигт байдлыг үнэлэх аргачлалыг ашиглан үнэлснээр төсөл хэрэгжих бүс нутгийн сонгон авсан тусгай хамгаалалттай газар нутгуудад менежментийн үр ашигтай байдал мэдэгдэхүйц сайжирсан байна,


2. Сонгон авсан ТХГН болон ОБ-ийн менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан ой (талхлагдсан ойн нөхөн сэргээлт)-н хамгаалал, тогтвортой менежментийн түвшин сайжирсан, ойн менежмент илүү тогтвортой болсон байна. Сонгон авсан ТХГН болон ОБ-ийн менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан бэлчээр, талхлагдсан бэлчээрийн хамгаалал сайжирч, менежмент нь илүү тогтвортой болсон байна,

3. Сонгон авсан ТХГН-уудад (Монголын Улаан ном болон тухайн ТХГН-ын МТ-нд тодорхойлсноор) ховордож буй амьтан ургамлын тоо толгой нь өссөн, тогтворжсон байна,

4. Сонгон авсан ТХГН болон ОБ-ийн нутгийн иргэдийн амьжиргааны түвшин дээшилсэн, тогтвортой болсон байна (байгалийн нөөцийн зүй зохистой менежмент, нийгэм эдийн засгийг дэмжих нэмэлт үйл ажиллагааг хэрэгжүүлнэ)

4.3. Хэрэгжилтийн үр ашгийн үнэлгээ

Үр ашиг нь тоон утга талаасаа эдийн засгийн тооцоололд суурилсан утга бөгөөд өнөөдрийн хэрэгжүүлж буй буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжиж буй төслийн хувьд шууд эдийн засгийн өгөөж, санхүүгийн шинжилгээ хийх нь тийм ч оновчтой бус. Гэвч төслийн хэмжээнд хэрэгжиж буй бүх ажиллагаа валют болон монгол төгрөгөөр хэмжигдэх тул үр ашгийн үнэлгээ зайлшгүй байна.



Аливаа зорилго, зорилтыг хэрэгжүүлэхдээ нөөц баялгийг зүй зохистой, үр ашигтай хуваарилан зарцуулах үйл ажиллагааг өрсөлдөхүйц төвшинд хүргэн, зөв оновчтой зохион байгуулж, бүтээмжийн өндөр үр дүнд хүргэх нь үр ашиг юм. Өөрөөр хэлбэр үйл ажиллагааг хамгийн бага зардлаар чанартай хийх юм.

Үр ашигт байдлын шалгуур үзүүлэлт гэдэг

- Гүйцэтгэлийн төвшин (Effectiveness)
- Хэмнэлт (Economy)
- Чанар (Quality)
- Ашигт ажиллагаа (Profitability)
- Хөдөлмөрлөх орчны чанар (Quality of Work Life)
- Шинэчлэлт (Innovation)
- Үр ашиг (Efficiency)
- Бүтээмж (Productivity)

Хоёр орны ЗГ хоорондын хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж байгаа төслийн хувьд үр ашгийг ашиг олох, хэмнэлт гэдэг утгаар шууд авч үзэх нь өрөөсгөл. Мэдээж үйл ажиллагааны чиглэлтэй холбоотой хэмнэлт гаргах, зөв зүйлд хөрөнгө оруулалтыг зарцуулах нь чухал.

Хүснэгт 12 Төслийг тайлагнах

Гадаадын тусламжийн төсөл, арга хэмжээг тайлагнах					
№	Тайлангийн төрөл	Журам	Хариуцах ажилтан	Хугацаа	Хэнд хүргүүлэх
1	Үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан	Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Тусгай гэрээнд заасны дагуу	Зөвлөх баг	Улирал тутам	Германы Сэргээн босголт зээлийн банк (KfW)
2	Үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу	Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан	Хагас жил тутам	БОАЖЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газар
3	Худалдан авалтын төлөвлөгөө, тайлан	Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 363 дугаар тушаалаар баталсан “ТБОНӨХБАҮХАА-г төлөвлөх, тайлагнах журам”	Худалдан авах ажиллагааны ажилтан нар	Сар тутам	БОАЖЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс
4	Санхүүгийн үйл ажиллагааны тайлан	Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалын хавсралт	Санхүүгийн ажилтан	Хагас жил тутам	Сангийн яаманд
5	Хяналт, шинжилгээний тайлан, төлөвлөгөө	МУ-ын ЗГ-ын 2016 оны “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журмыг батлах тухай” 176 дугаар тогтоол, Сангийн сайдын 2016 оны 193 дугаар тушаалын хавсралт маягт	Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан	Тухай бүр	Удирдах хорооны хурлаар танилцуулна Үр дүнд суурилсан ХШҮ-ний удирдлагын мэдээллийн нэгдсэн санд байршуулна
6	Ашиглалтын тайлан мэдээ НӨАТ-ын тайлан НД-ын шимтгэлийн тайлан ХАОАТ-ын тайланг		Санхүүгийн ажилтан	Сар бүр	БОАЖЯ, СЯ баталгаажуулан KfW банканд
					Татварын ерөнхий газарт
					СБД-ийн НД-ын хэлтэс, татварын хэлтэст

5. НИЙЦТЭЙ БАЙДАЛ БА ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

5.1. Стратегийн зорилготой нийцтэй байдал

Төслийн үйл ажиллагаа нь байгаль экологийн талаар төрөөс баримталж буй дараах бодлогын баримт бичгүүдийн стратегийн зорилго, зорилттой нийцэж байгаа болно.

Хүснэгт 13. Төсөл уялдан хэрэгжих бодлогын бичиг баримтууд

д/д	Стратеги, бодлого	Бодлогын холбогдох заалт
1	“Төрөөс экологийн талаар баримтлах бодлого” (УИХ, 199	“Монгол орны байгалийн бүс, бүслүүрийн үндсэн хэв шинж, иж бүрдлийг төлөөлсөн өвөрмөц тогтоц бүхий үзэсгэлэнтэй газар, биологийн төрөл зүйл, соёлын үнэт өвийг тусгай хамгаалалттай газар нутгийн хүрээнд сүлжээнд хамруулан хамгаалах, нөхөн сэргээх цогцолбор арга хэмжээг олон улсын дэмжлэг туслалцаатайгаар хэрэгжүүлэх чиглэл баримтална”,
2	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” (УИХ, 2001)	“Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг бүс нутаг, хот, тосгоны хөгжлийн чиг хандлагатай уялдуулан боловсронгуй болгох”;
3	“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” /УИХ, 2008/	“Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэн түүний удирдлагын тогтолцооны оновчтой бүтцийг бий болгож, орчин үеийн шаардлага хангасан хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэх”;
4	“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” (УИХ, 2010)	“Нэн ховор, ховор болон экосистемд онцгой үүрэгтэй амьтан, ургамал бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авч, тэдгээрийн амьдрах орчныг тэтгэхэд биотехникийн аргыг түлхүү хэрэглэнэ”;
5	Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтууд” (УИХ, 2005	Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн нийт нутаг дэвсгэрт эзлэх хувийг 2015 онд 30%-д, үүнээс 15%-ийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах
6	“Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр” (УИХ, 1998)	“Байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцлийг хангах, байгалийн баялгийг арвижуулах, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах зорилгоор байгалийн бүс бүслүүрийн үндсэн шинж, иж бүрдлийг төлөөлсөн экологийн онцгой ач холбогдол бүхий газар нутгаар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, нийт нутаг дэвсгэрийн 30-аас доошгүй хувьд хүргэнэ”
7	“Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний	“Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг биологийн олон янз байдлыг хамгаалах, дасан зохицоход дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тусгай хамгаалалттай газар нутгийг түшиглэн хэрэгжүүлэх”, “Тусгай хамгаалалттай газрыг түшиглэн

	хөтөлбөр” (УИХ, 2011)	биогеоценозын ажиглалт, мониторингийн сүлжээ, ой, хээрийн түймрийн тандалт, судалгааны цэгийг байгуулах”
8	“Ногоон хөгжлийн бодлого, 2014-2020” (УИХ, 2014)	Байгалийн унаган төрх, экосистемийн тогтвортой байдлыг хадгалах, нэн ховор, ховор амьтан, ургамлын үндсэн тархац нутгийн 70-аас доошгүй хувь, ойн сан, томоохон мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулж 2020 онд нийт нутаг дэвсгэрийн 25 хувь, 2030 онд 30-аас доошгүй хувьд хүргэж, хамгаалалтыг сайжруулах зорилтыг тавьсан.
9	“Төрөөс ойн талаар баримтлах бодлого” (УИХ, 2015)-д	Монгол орны ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, ойн хомсдол, доройтлыг зогсоох, ойг нөхөн сэргээх, зохистой ашиглахад чиглэсэн ойн тогтвортой менежментийг буй болгох зорилтуудыг тодорхойлсон.
10	Ус үндэсний хөтөлбөр”: (ЗГ, 2010-2021 2010)-	“Монгол орны гадаргын усны нөөцийн 70 гаруй хувийг бүрдүүлэх, сав газрын эхэд хамаарах хэсгийг улсын болон орон нутгийн хамгаалалтад авч “гол, мөрний урсац бүрэлдэх эхийн 60 хувьд хамаарах газрын хилийг нарийвчлан тогтоож, улсын болон орон нутгийн хамгаалалтад авна”
11	Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр	2030 он гэхэд экосистемийн үндсэн төлөөлөл тус бүрийн 30-аас доошгүй хувь, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өвөрмөц экосистемийг бүхэлд нь тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулж, менежментийг нь сайжруулах, 2020 он гэхэд ТХГН-ийн хамгаалалтын захиргааны дэд бүтцийг сайжруулан, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлсэн байна. 2025 он гэхэд Биологийн олон янз байдлын талаарх шалгуур үзүүлэлтийг Үндэсний тооцооны системд нэвтрүүлж, холбогдох салбарын хөтөлбөрийн мониторинг үнэлгээний системд тусгах
12	Алсын хараа 2050 (ЗГ, 2019)	Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем 6.1.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлнэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем 6.1.2. Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг улсын хэмжээнд үе шаттай хийж нөөцийн өөрчлөлтийг шинэчлэн тогтоож, зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. 6.2.2. Амьтан, ургамлын улаан дансыг шинэчлэх, шинээр бий болгож, ховордсон зүйлийн хамгааллын арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил 1.1.25.Сурах бичиг, сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн, цахим болон зайн сургалтын хүртээмжийг нэмэгдүүлж, суралцагчдын ялгаатай хэрэгцээг хангасан байхаар боловсруулж, түгээнэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил- Шинэжлэх ухаан, инновац 2.4.12.

	Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд суурилсан шагнал, урамишууллын тогтолцоог бий болгоно. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин 2.5.2. Орон сууцны чанар, стандартыг ханган, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлнэ. 2.5.4. Орон сууцны халаалт, эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангана. 2.5.6. Ногоон байгууламжийн усалгаанд хур тунадасны болон саарал усыг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Гэр бүл 2.3.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг тогтмол нэмэгдүүлнэ. 2.4.10. Аж үйлдвэрийн тэргүүлэх салбарт дэвшилтэт болон шинэ технологи, бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгосон, нэвтрүүлсэн, нутагшуулсан аж ахуйн нэгжийг гааль, татвар, зээлийн бодлогоор дэмжинэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Амьдралын чанар ба дундаж давхарга- Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес 3.3.15. Гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлнэ. /хурдасгуур хөтөлбөр, менторишп, co-work-ing space, түрээсийн хөнгөлөлт/ Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Амьдралын чанар ба дундаж давхарга - Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт 3.4.2. Барьцаа хөрөнгийн, зээл авах хүсэлтэй бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд Засгийн газрын зүгээс санхүүжилтийн баталгаа гаргах үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин 2.5.20. Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулах, хүнсний сүлжээний бүх шатанд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хүнсний салбарын стандартуудыг олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартад хүргэхэд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлнэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хөдөлмөрийн зах зээл 2.6.15. Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хүн амын аюулгүй байдлыг хангах болон мэргэжлийн өндөр ур чадвар, технологийг хөдөлмөрийн зах зээлд нутагшуулах бодлоготой уялдуулна.
--	--

5.2. Бодлогын орчин

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015-2025)-г ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалан хамгаалах зорилгоор 2030 он гэхэд хамгаалах шаардлагатай экологийн хувьд чухал ач холбогдолтой 215

газраас 63 байршлын 15,3 сая га газрыг улсын тусгай хамгаалалтад авч, ТХГН-ийн хэмжээг 30 хувьд хүргэнэ гэж заасан.

5.3. Эдийн засаг, санхүүгийн үндэслэл

2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Монгол Улсын “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. БОАЖ-ын сайдын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн тушаалаар Улсын тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоосон.

Хүснэгт 14: ТХГН-т нэвтрэх тасалбарын төрөл



Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамж хураах журмыг саяхан баталж, мөрдөж эхэлсэн. Хувь хүний элсэлтийн төлбөрийг дараах зүйлд үндэслэн тооцно.

- тусгай хамгаалалттай газар нутгийн төрөл,
- хүний тоо (гадаадын иргэн, монгол иргэн хоёрын ялгаа байхгүй)
- тээврийн хэрэгслийн төрөл

Хүснэгт 15: ТХГН-т нэвтрэх хураамжийн хэмжээ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/71 дүгээр тушаалын хавсралт

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ НЭВТРЭХ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ												
(төгрөгөөр)												
№	ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН АНГИЛАЛ	ТӨЛБӨР ТӨЛӨГЧИЙН АНГИЛАЛ										
		Тээврийн хэрэгсэл										
		Иргэн	Мотоцикл	Суудлын авто машин	Автобус			Ачааны машин		Нисдэг тэрэг, онгоц		
					(12 хүртэл хүний суудалтай)	(12-24 хүний суудалтай)	(24-өөс дээш хүний суудалтай)	(3.5 тн хүртэл бодит жинтэй)	(3.5 тн-оос дээш бодит жинтэй)	(5 хүртэл хүний суудалтай)	(5-12 хүний суудалтай)	(12-оос дээш хүний суудалтай)
1	Дархан цаазат газар	5,000	5,000	15,000	50,000	90,000	120,000	30,000	50,000	300,000	400,000	500,000
2	Байгалийн цогцолборт газар	3,000	3,000	9,000	30,000	54,000	72,000	20,000	40,000	100,000	200,000	300,000
3	Байгалийн нөөц газар	2,000	2,000	6,000	20,000	36,000	48,000	15,000	30,000	80,000	160,000	240,000
4	Байгалийн дурсгалт газар	1,000	1,000	3,000	10,000	18,000	24,000	10,000	20,000	60,000	120,000	180,000

Тайлбар: 1. Нэвтрэх хураамжийн төлбөр төлөгчийн ангиллыг давхардуулахгүй.
2. Ачааны машин, нисдэг тэрэг, онгоцонд нэвтрэх хураамжийн төлбөрийг заавал ноогдуулна.
3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гэрээгээр гүйцэтгүүлж буй хамгаалалтын захиргаадын үйл ажиллагаанд энэхүү хураамжийн хэмжээ хамаарахгүй болно.

Дээрх хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилтийг хангах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар тусгай хамгаалалттай газар нутгаар нүүрс тээвэрлэж буй 3.5 тонноос дээш даацтай автомашинуудад төлбөр ногдуулах чиглэл өгсөн. Төлбөрийг дархан цаазат газар нэг машинаас 50 мянган төгрөг, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 45 мянган төгрөг байхаар тогтоожээ. Эдгээр арга хэмжээ нь ТХГН-ийн санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийн тогтвортой менежментэд хувь нэмэр оруулах зорилготой, аялал жуулчлалын орлогыг нэмэгдүүлэх төлөвтэй байна.


5.4. Институтийн хүчин чадал



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Төслийн бүтэц, бүрэлдэхүүн



5.5. Нийгэм-соёлын асуудал

Төслийн хэрэгжиж буй газар нутгийн хувьд баруун болон говийн бүс нутгийн аймгуудыг хамарч байна. Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүс дэх амьдарч буй бүх л нийгмийн давхаргыг хамарч, ямар нэг байдлаар иргэдийн зан заншил, соёлоор ялгаварлах үзэлгүйгээр тэгш хүртээмжтэй үр дүнг бий болгох нь баримтлах зарчмуудын нэг.

Төслийн II, III шатны хүрээнд ТХГ-ын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих санхүүгийн арга хэмжээг зохион байгуулахаар ажиллаж байна. Мөн дээр нь орчны бүсийн сумдын иргэдийн боловсролын болон эрүүл мэндийн салбарт тулгамдсан асуудлыг

шийдвэрлэхэд хөрөнгө оруулалтын туслалцаа үзүүлэн ажиллаа. Үүнд: Тусгай хамгаалалттай газар нутгийн Орчны бүсийн сумдын сургуулийн эко кабинет байгуулах тавилга, компьютер, тоног төхөөрөмжөөр хангах, орчны бүсийн сумдыг эмнэлгийн түргэн тусламжийн машинаар хангах зэрэг ажлууд болно.

5.6. Оролцоо ба өмчлөл

Ямар нэг техникийн туслалцааг үзүүлэхдээ хэрэгцээ, шаардлагаас гадна үйл ажиллагааг өргөжүүлэх, үр дүнтэй менежментийг бий болгох удирдлагын төлөвлөгөөг үндэс болгох ёстой. Ийм хөрөнгө оруулалтыг оруулахдаа анхан шатны нэгжүүдэд хэрэгцээ шаардлагын судалгааг нарийвчлан авах, мөн бодлогын газар болох БОАЖЯ-ны төлөвлөгөө, стратегитай уялдуулан тал бүрийн оролцоог хангаж ажиллах нь чухал.

Оролцоо: Буцалтгүй тусламжийн хүрээнд техникийн туслалцаа үзүүлэхдээ бодлого боловсруулагч газрын стратеги, төлөвлөгөөг харгалзан үздэг энэ төслийн хүрээнд хийгддэг ихэнх төслийн хэрэгцээ шаардлага орон нутгаас, байгаль орчны байгууллагуудын анхан шатны нэгжийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан гардаг. Иймийн тулд эхлэлийн шатанд суурь судалгааг бүх хэлбэрээр авдаг.

Өмчлөл: Аливаа нэгэн техникийн туслалцаа үзүүлж байгаа нь цаанаа тухайн үйл ажиллагааг цаашид тогтвортой байдлыг бий болгох, суурь үр дүнг сайжруулах зорилготой байдаг. Тухайн тоног төхөөрөмж, бусад туслалцааг үр дүнтэй болгоход өмчлөлийн асуудал маш чухал. Одоогийн байдлаар туслалцааны бүх зүйл төрийн мэдлийн буюу анхан шатны нэгжийн өмчлөлд бүртгэлтэй явж байгаа. Төслийн явцад орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжихийн тулд хувийн хэвшилд өмчлөлийн хэлбэрийг бий болгохоор зорин ажиллаж байна.

5.7. Жендер

Тус төсөл нь санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж байгаа төсөл бөгөөд 2023 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд жендерийн ажил хийгдээгүй болно.

5.8. Байгаль орчин

Сонгогдсон ТХГН-ийн БОЯБ-ын суурь судалгаа хийх" зөвлөх үйлчилгээний эцсийн тайланг төслийн "БОЯБ-ын мэргэжлийн зөвлөл"-ийн гишүүдээр 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр хэлэлцүүлэн хүлээн авсан.

5.9. Тохиромжит технологи

Төслийн хүрээнд хийгдэх хөрөнгө оруулалт шууд болон шууд бусаар хүрээлэн буй орчиндоо эерэг нөлөө үзүүлэх чиглэлийг баримталж ажилладаг. Энэ нь нэг талаараа мэргэжлийн байгууллагуудын судалгаа шинжилгээ, мониторингийн ажилд дэмжлэг үзүүлж, боловсон хүчний чадавх, ажиллах орчныг сайжруулах, нөгөө талаар орчны бүс дэх иргэдийн амьжиргааг дэмжих, байгаль орчинд ээлтэй бизнесийг дэмжихэд анхаарч ажилладаг.

6. ХЭРЭГЖИЛТИЙН ҮР АШГИЙН ҮНЭЛГЭЭ

Төслийн үр ашгийн үнэлгээг дараах байдлаар гаргаж дүгнэдэг. Үүнд:

- УХ-ны хурал (жилд 1-3 удаа);
- Үнэлгээний хорооны хурал (тендер бүрд)
- ТХН-ийн явцын мониторингийн үнэлгээ (үйл ажиллагаа тус бүрээр)
- Аудитын үнэлгээ (жилд 1 удаа);

- Дунд хугацааны үнэлгээ (улирал тутам);
- ГСБЗБ-ны явцын үнэлгээ (жилд 1 удаа);
- ГСБЗБ-ны явцын үнэлгээний протоколын биелэлт (хагас жил тутам)
- Төслийн үйл ажиллагааны тайлан (БОАЖЯ-ны УАӨГ, ГХАГ-т хагас жил тутам)
- Төслийн худалдан авах ажиллагааны тайлан (БОАЖЯ-ны НХБЗГ-т хагас жил тутам)
- Төслийн хяналт, шинжилгээний тайлан (СЯ-нд жил тутам)
- Төсөл хэрэгжилтийн тайлан (ГСБЗБ-нд хагас жил тутам, ЭКО КОНСАЛТ Зөвлөх компанид улирал тутам)
- Шилэн дансны тайлан мэдээ (сар тутам)
- Үр дүнд суурилсан Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлагын мэдээллийн нэгдсэн сан (ODAMIS)-гийн мэдээ (тухай бүрд)

Германы KfW банкнаас жил бүр явцын үнэлгээний баг Монголд ирж ажилладаг ажлын хүрээнд дэлхий нийтэд үүсээд байгаа /Ковид-19/ цар тахлын улмаас KfW банкны төслийн менежер, зөвлөхүүд 2020 онд томилолтоор ажиллаагүй. Иймд KfW банкны монгол дахь суурин төлөөлөгчийн газартай хамтран KfW банкны суурин төлөөлөгч Михайл Зумзераар ахлуулсан төслийн явцын үнэлгээний баг төв, хангай болон баруун бүсэд 2021 оны 05 дугаар сард Архангай, Завхан, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, зүүн бүсэд 07 дугаар сард Хэнтий, Дорнод, Сүхбаатар, говийн бүсэд 12 дугаар сард Дундговь аймагт тус тус ажиллаж, төслийн I үе шатны хэрэгжилтийг дүгнэж, II, III үе шатны үйл ажиллагаа, төсөлд хамрагдсан кластеруудын танилцуулгыг хийж, явцын үнэлгээний ажлыг зохион байгуулсан. Үнэлгээний багт KfW Банкны УБ дахь төлөөлөгчийн газар, БОАЖЯ, ТХБНУГ, ТХН, ЗБ-ийн төлөөллүүд оролцсон.

7. ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ: ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ САНАЛУУД, СУРГАМЖ

2023 онд төслийн нэгжийн үйл ажиллагаанд нөлөөлөх дараах хүчин зүйлс гарсан. Үүнд: Төслийн удирдлагууд удаа дараа солигдож, төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнууд шинэчлэгдсэн. ОХУ-Украины дайн, дэлхий нийтэд үүсээд буй эдийн засгийн хүнд байдал, мөнгөний ханшны тогтворгүй байдал, инфляцын нөлөөгөөр тендерүүдэд нөлөөлж, гэрээнүүд сунгагдаж, гүйцэтгэл хойшилсон. Гэвч төслийн хэмжээнд гарсан уг үр дүнгээр бус жилийн сүүлийн хагас жилд хийгдсэн ажлын ачааллыг тухайн хийж гүйцэтгэсэн хугацаанд (6 сард) харьцуулан авч үзвэл өмнөх жилүүдээс илүү өндөр бүтээмжтэй ажилласан нь харагдаж байна.

Төслийн 2023 оны үйл ажиллагааны хэрэгжилт 75,9 хувьтай, зарим нэг ажил хоцрогдолтой он дамжиж хийгдэхээр хойшилсон, ялангуяа төлөвлөөд хэрэгжээгүй ажлуудад барилгын ажлууд дийлэнх байна. Хэрэгжээгүй ажлуудыг харахад баруун бүсийн төвийн барилга барих бэлтгэл ажлууд болон УТХГ-ын хамгаалалтын захиргааны болон байгаль хамгаалагчийн байр барих ажлууд байна. Төслийн хүрээнд төлөвлөсөн барилгын ажлуудын үзэл баримтлал, концепцийг зөвлөх багаас боловсруулсан боловч, шаардлага хангаагүй, бодит бус, чанар хангаагүй зэргээс шалтгаалан ажлын даалгавар, зураг төсөл зэрэг тендер зарлах бэлтгэл ажил хангагдаагүйгээс барилгын холбогдолтой тендерүүд хэрэгжээгүй нь төслийн 2023 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд томоохон сөрөг үзүүлэлт

болсон. Дээрх гадаад болон дотоод олон хүчин зүйлээс шалтгаалан 2023 оны ажлын гүйцэтгэл хангалтгүй үнэлэгдэх үндэслэл бүрдсэн.

Иймд 2024 онд, ялангуяа барилгын ажлын бэлтгэл ажлыг урьдчилан хангах, төсөв болон биелэлтийн хугацааг бодитоор тооцоолох, ажлын даалгаврыг цаг хугацаанд нь, чанартай боловсруулж байх шаардлагатай байна.

ХАА амжилттай зохион байгуулагдах эсэх нь ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын зөв боловсруулалтаас хамаарах учир үйл ажиллагааны энэхүү шат маш чухал юм. Ажлын даалгавар нь тухайн ХАА-ны үндэс, суурь тул төслийн хүрээнд нийлүүлэх ажил, бараа, үйлчилгээний хэрэгцээ шаардлага, чанар, цаашилбал төслийн үр дүн, үр нөлөө хүртэл шалтгаалах тул анхаарч ажиллах нь чухал байна.